

БНСУ-ын Цаг уурын төвд “Урьдчилсан мэдээний чанарыг сайжруулах”
сэдэвт богино хугацааны сургалтад хамрагдсан товч тайлан

Улаанбаатар хот

2024.07.09

Нислэгийн цаг уурын төвийн Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн Урьдчилсан мэдээлэхийн ерөнхий технологич инженер Б.Сарангэрэл БНСУ-ын Цаг уурын төвөөс зохион байгуулсан “Урьдчилсан мэдээний чанарыг сайжруулах” сэдэвт богино хугацааны сургалтад 2024 оны 5 дугаар сарын 20-31-ний өдрүүдэд оролцсон.

Энэхүү Олон улсын сургалтын зорилго нь Урьдчилсан мэдээний чанарыг сайжруулах, радарын мэдээнд дүн шинжилгээ хийх ашиглах, урьдчилан мэдээлэх тоон загварууд NWP, KIM гэх мэт загваруудын үр дүнтэй танилцах, цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэхэд уламжлалт болон хиймэл дагуулын ажиглалтын хэрэглээг сайжруулах юм.

Сургалтад Лаос, Вьетнам, Филиппин, Индонез, Камбож, Монгол зэрэг нийт 6 орны 15 хүн оролцсон. БНСУ-ын Их сургуулийн багш нар болон БНСУ-ын Цаг уурын төвийн байгууллагын багш нар хичээл заасан.

Нийт 30 цагийн лекц бүхий дараах сэдвээр явагдсан. Үүнд:

- Радарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
- Аюултай цаг агаарын танилцуулга;
- БНСУ-ын Цаг уурын ажиглалтын бодлого, сүлжээний танилцуулга;
- Цаг агаар, уур амьсгалын загварт физик процессын параметржилт;
- Цаг агаарын урьдчилан мэдээлэхэд ашиглагддаг илэрхийлэл, томъёоллуудыг тоон аргаар шийдэх;
- Уур амьсгалын болон Цаг агаарын ажиглалтын мэдээнд сансрын мэдээллүүдийг ашиглах;
- NWP модул-ийн өгөгдөл ассимиляцийн системд ассимиляци хийх;
- Уур амьсгалын өөрчлөлт;
- Богино зайнд болон хязгаарлагдмал талбайн тоон таамаглалын системийн ажиглалтын танилцуулга;
- БНСУ-ын хэл, соёлын танилцуулга

Дээрх сэдвүүдийн хүрээнд онол болон практикийн хичээлийг тухай бүр нь хослуулан явуулсан бөгөөд NWP загвар ассимиляци хийх системүүдийг тохируулга хийж суулгах, түүнийгээ ажиллагаанд оруулах, хиймэл дагуул болон төрөл бүрийн ажиглалтын мэдээг ашиглаж NWP загварын системээр цаг агаарыг урьдчилан мэдээлэх, дүн шинжилгээ хийх,

Дүгнэлт:

Энэ сургалт нь миний хувьд олон улсын салбар бүрд ажиллаж буй цаг уурчид, физикч, их сургуулийн багш, магиструуд болон БНСУ-ын Урьдчилсан мэдээлэхийн инженер нартай танилцаж, мэдээлэл хуваалцсан өдрүүд байлаа. Цаашид хиймэл дагуулын мэдээлэл болон цаг уурын бодит ажиглалтын мэдээллүүдийг ашиглан NWP

загвараас гаргаж буй үр дүнд дахин өгөгдлийн ассимиляци хийж, туршиж үзэх нь нислэгийн цаг уурын төвөөс гаргаж буй төрөл бүрийн урьдчилсан мэдээний чанар, таарцыг дээшлүүлэхэд түлхэц болохуйц үр дүнтэй болно гэж үзэж байна.

Тайлан бичсэн: 

Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер:

Б.Сарангэрэл